

ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2025.11.28

Д/Д	Зорилт	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилт
Хоёр.Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулж, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх			
1	2.1.Молекул биологи, молекул генетикийн оношилгооны чадавхыг сайжруулах	Уушги, ходоод бүдүүн гэдэс хөх болон бусад хорт хавдрын бай, дархлаа эмчилгээнд шаардлагатай генийн мутаци тодорхойлох бхПГУ-ын шинжилгээний үзүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлэх	ЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, Гэгээн Жүд Хүүхдийн Судалгааны эмнэлэг, ялангуяа бага, дунд орлоготой орнуудад хорт хавдраар өвчилсөн хүүхдүүдийг эмчлэх чанарын баталгаатай хорт хавдрын эмээр тасралтгүй хангах зорилгоор Хүүхдийн хорт хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах дэлхийн платформыг санаачилсан. ЭЭХХЗГ-ын даргаар “Хүүхдийн хорт хавдрын тусламж үйлчилгээг сайжруулах хүрээнд GPACCM-ээр дамжуулан цитотоксик эм хүлээн авахтай холбоотой тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэх” сэдэвт удирдамж батлагдсан. Энэхүү удирдамжийн дагуу дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд 1. Эмийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлөөр хүлээн авах, хадгалах, түгээх үйл ажиллагаанд хяналт тавих тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2025 оны А/199 дүгээр тушаалаар “Хяналтын хуудас боловсруулах” ажлын хэсэг байгуулсан. Төрийн өмчит эрүүл мэндийн газруудаас саналыг авч аймаг, нийслэлийн 30 Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын улсын байцаагч нар хэлэлцүүлсэн. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 2025 оны 7-9 сард “Эрүүл мэндийн байгууллагын эм зүйн тусламж үйлчилгээг шалгах хуудас”-ын 10.16.4-өөр хяналт шалгалт хийхэд бага эрсдэлтэй үнэлэгдсэн. 2025 оны 4-р улиралд цитотоксик эмийн хяналтын хуудсаар эм хадгалах, түгээх, найруулах үйл ажиллагааг шалгахад бага эрсдэлтэй үнэлэгдсэн. 2. ЭЭХХЗГ-ын даргаар “Хүүхдийн хорт хавдрын тусламж үйлчилгээг сайжруулах дэлхийн платформ үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой “эс хордуулах химийн эмчилгээний эм бэлтгэх стандарт ажиллагааны заавар” сэдэвт сургалтын удирдамж батлагдсан. Тус удирдамжийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд Эс хордуулах химийн эм бэлдмэл найруулах технологид тавигдах ерөнхий шаардлага, техник аюулгүй ажиллагааны зааварчилгаа, эс хордуулах эм бэлдмэлийг найруулан бэлтгэх, эс хордуулах эм бэлдмэлтэй харьцахад шаардлагатай хог хаягдал, асгаралтын менежмент сэдвээр нийт 55 оролцогчийн хүрээнд сургалтыг амжилттай зохион байгуулсан. 3. Эс хордуулах эмийн гаж нөлөөг хянах, бүртгэх ажлын материал орчуулж

			бэлтгэх, сургалтын гарын авлага боловсруулах, хянах үйл ажиллагааны хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/164 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв дээр Фармаковижилансийн талаарх ойлголт өгөх, мөн эс хордуулах эмийн гаж нөлөөг “Фармаковижилансийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу хэрхэн мэдээлэх болон идэвхтэй фармаковижилансийн үйл ажиллагааны талаарх сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, сургалтад ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ЦЭХСТ-ийн 37 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар дээр шинээр батлагдсан журам танилцуулах сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, сургалтад Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ЦЭХСТ-ийн 20 эм зүйч, сувилагч, эмч нар хамрагдав. 4. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран тус эмнэлэгт төслөөр нийлүүлэгдэж буй эмийн нэр төрөлд үндэслэн бүртгэлд шаардлагатай дата сан үүсгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой эм тус бүрийн хэрэглэх заавар, фармакокинетик, фармакодинамик болон бусад холбогдох мэдээллийг цуглуулж, боловсруулсан.
2	2.7.Хавдрын системийн эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх	Эмнэлзүйн удирдамж стандартад үндэслэн хими бай, дархлаа болон даавар эмийн нэр төрлийг нэмэгдүүлэх	“Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам”-ыг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр эрүүл мэндийн байгууллагуудад БНСУ-ын Korea United Pharm Inc., үйлдвэрийн 5 нэрийн хавдрын эмийн 1 жилийн хэрэгцээг ирүүлэх тухай 01/1130 дугаар бичиг хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд нийт 32 эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн саналыг нэгтгэн 2025.06.12-ны өдрийн 01/1231 дүгээр бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн. Эмийн зөвлөлийн 2025.06.17-ны өдрийн хурлаар нэг эх үүсвэрийн аргаар худалдан авсан эмийн нэр төрөлд нэг удаагийн импортын мэдүүлэг олгох тухай асуудлыг хэлэлцүүлж, Эмийн зөвлөлийн 06 дугаар хурлын шийдвэрээр БНСУ-ын Korea United Pharm Inc үйлдвэрээс нэг үүсвэрээр худалдан авах дараах 5 нэрийн хавдрын эмэнд нэг удаагийн импортын мэдүүлэг олгосон. Үүнд: - Хавдрын тусламж үйлчилгээнд хэрэглэдэг (5) БНСУ-ын Korea United Pharm үйлдвэрийн Карбоплатин 450мг/45мл, тарилгын уусмал, Цисплатин 50мг/50мл, тарилгын уусмал, Дакарбазин 200мг, тарилгын уусмал бэлтгэх

			лиофилизат нунтаг, Дактиномицин 0.5мг, тарилгын уусмал бэлтгэх лиофилизат нунтаг, Метотрексат 50мг/2мл, тарилгын уусмал эм Мөн ЭЭХХЗГ-аас 2025.10.17-ны өдрийн 01/1909 дүгээр бичгээр Атом хөтөлбөрийн хүрээнд хандиваар нийлүүлэх эмийн нэг жилийн хэрэгцээний саналыг УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ-өөс авч, нэгтгэн ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газарт хүргүүлсэн. Уушгины хорт хавдрын эмчилгээнд шаардлагатай олон улсын нэршлээр Крезотиниб 200мг; 250мг худалдааны нэршлээр Ксалкори эмийн 1 жилийн хэрэгцээг хүргүүлсэн.
3	4.2.3.Эмнэлзүйн туршил судалгааг хөгжүүлэх	Шинээр нэвтрүүлсэн эм, бэлдмэлийн тоо	Шинээр нэвтрүүлсэн эм, бэлдмэл байхгүй
Гурав.Уушгины хорт хавдрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө			
4	3.3.3.Уушгины хорт хавдрын эрт, илрүүлэг оношилгоо, эмчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг сайжруулах нэгдсэн худалдан авалтаар авах зохицуулалтыг хийх	Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж цахим дэлгүүрт байршсан эм, эмнэлгийн хэрэгслийн тоо	Эрүүл мэндийн сайдын 2025. 01.08-ны өдрийн А/04 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу хорт хавдрын эрт илрүүлгийн үед хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгсэл лабораторийн урвалж бодис, оношлуур, дагалдах хэрэгслийн жагсаалтын шинэчлэн боловсруулж нийт 20 ханган нийлүүлэх байгууллага, эрүүл мэндийн 54 байгууллагуудаас нөөцийн мэдээллийг 3 удаа нөөцийн судалгааг хийж ЭМЯ-ны Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажилласан. Мөн хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмж, хангамжийг сайжруулах, нэгдсэн худалдан авалтаар авах, зохицуулалтыг хийх зорилгоор Цахим дэлгүүрт эрт илрүүлэгт шаардлагатай 9 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл байршуулсан. Үүнд: 1. Тариур 1г -20г 2. Ариутгасан хөвөн 3. 70% спирт 4. 96% спирт 5. Нэг удаагийн маск 6. Нэг удаагийн халад 7. Малгай 8. Эхо -ны гель 9. Ариутгасан самбай